

ОБЪЕКТЫН ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Ц.Саруулсайхан

*Дотоод хэргийн их сургуулийн Ахисан шатны боловсролын сургуулийн
гамшиг судлалын магистрант, ахлах дэслэгч*

ҮНДЭСЛЭЛ: Галын аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Гал түймэр унтраах дүрмийн шинэчилсэн найруулга, орчин үеийн чиг хандлагад нийцүүлж гал түймэр унтраах нэн ялангуяа объектын гал унтраах аргыг сайжруулах хэрэгцээ, шаардлагатай байна. Орчин үед нийгмийн хурдацтай хөгжлийг дагаад гамшиг, гал түймрийн давтамж нэмэгдэж байгаа тул "эрдэмтэн судлаачид, Онцгой байдлын байгууллагын мэргэжилтнүүд гал түймрийн аюул нь бодитой нэмэгдэх тул бид түүнийг үгүй болгож чадахгүй, харин учирч болох хохирлыг нь бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг хийх хэрэгтэй" гэж үзэж байгаа юм.

УИХ-аас 2015 онд шинэчлэн батлан гаргасан Галын аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгад гал түймэртэй тэмцэх нэгжид сайн дурынханыг тусгасан нь иргэдийн оролцоог хангах эрх зүйн орчинг хуульчилж өгсөн байна.

Иймд цаг үе, нийгмийн хөгжлийг даган алба хаагчдын гал унтраах мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх боломж байгааг судлах хэрэгцээ, шаардлагатай гэж үзэж энэхүү сэдвийг дараах үндэслэлүүдээр сонгож байна. Үүнд:

1. Галын аюулгүй байдлын тухай хуульд зааснаар бол:

18.2. Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөнд 10000-аас дээш хүн ам төвлөрсөн суурин газарт гурван километрийн радиуст, эсхүл 4000 хүн ам тутамд гал түймэр унтраах, аврах анги алслагдсан суурин газарт 2000 хүн ам тутамд гал түймэр унтраах, аврах анги эсхүл гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг үйлчилж байхаар тусгана гэж заасан байдаг. Одоогийн байдлаар Монгол орны нутагт гал түймэр унтраах, аврах анги нийт 66-тай, 5000 орчим алба хаагчид байдаг. Энэ нь улс орны хэмжээнд газарзүйн байрлалаар нь авч үзвэл гал түймрийн үед үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүний хүрэлцээ хангалтгүй, хугацаа алдах шалтгаан байгааг харуулж байна.

2. Иргэд төдийгүй нийгмээрээ гал түймэр унтраах үйл ажиллагаанд хандах хандлага нь илүүтэй нэмэгдэж байгаа тул тэднийг зөв

зүйтэй чиглүүлэх, сошиал ертөнц хурдацтай хөгжиж буй цагт алба хаагчдыг чадавхижуулж иргэдэд мэргэжлийн заавар зөвлөмж өгөх, удирдлагаар хангах замаар галын аюулаас сэргийлэх арга зам шаардлагатай байна.

3. Гал түймэр унтраах үйл ажиллагаанд гарч буй хүндрэл бэрхшээлүүдэд алба хаагчдыг мэргэшүүлж ирээдүйн залгамж халааг чадавхижуулах,

4. Хууль сахиулахын их сургуулийн Онцгой байдлын сургуулийг төгсөж буй сонсогчдод практик байгууллага дээр тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг судалж хэлэлцүүлэн сургалтын хөтөлбөрт санал оруулж үр дүнд хүрэх шаардлагатай гэж үзэж энэ сэдвийг сонгож байна.

Тус судалгааны ажилд Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 04 ангиас тус бүр 5 алба хаагчдаас түүврийн арга хэрэглэн асуулгын хэлбэрээр судалгаа авч дүн шинжилгээ хийлээ. Үүнд:


1. Асуулт: Объектын гал түймэр унтраах ажиллагааг сайжруулах боломж байна уу?

А. Байгаа-46

Б. Байхгүй -0

В. Сайн мэдэхгүй байна-4

■ байгаа ■ байхгүй ■ сайн мэдэхгүй байна



2. Объектын гал түймэрт голчлон юун дээр их алдаж байна вэ?


А. ГУУ-н шийдвэр-1

Б. Барилгын хийц бүтээц-8

В.Объектын зам гарц-16

Г.Иргэдийн мэдээлэл-25

■ ГУУ-н шийдвэр ■ Барилгын хийц бүтээц ■ Объектын зам гарц ■ Иргэдийн мэдээлэл




3. Таны бодлоор Гал түймэр унтраах үед ихэвчлэн юуг анхаармаар санагддаг вэ?

- Ард иргэдийн мэдээлэл
- Зам гарцын судалгаа
- Хотын түгжрэл
- Гудамж, гудамжны тэмдэглэгээ
- Цахилгаан, газ, утаажилт
- ХАБЭА

4. Тухайн алба хаагч бүрт гал унтраах ажиллагаанд тулгамдаж буй асуудал?

А.Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл-31 Б.Алба хаагчдын мэргэжлийн ур чадвар-18 В.Задаргаа хийх хүндрэлүүд-1

■ Тоног төхөөрөмж багаж хэрэгсэл ■ Мэргэжлийн ур чадвар ■ Задаргаа хийхэд гарах хүндрэл




5. Дээрх хүчин зүйлсээс сонгосон шалтгаанаа товчхон тайлбарлаж бичнэ үү?

- Тоног төхөөрөмж багаж хэрэгсэлтэй зөв харьцах дадлага сургуулилт
- Гал түймэр унтраах даралтын хоолой муу, хадгалалт удаан тул элэгдэлд орсон
- Алба хаагч бүрийг практик сургалтанд ойртуулах

- ХАБЭАхуйн дүрмийг мөрдлөг болгохоос амьдралд тэр бүр хэрэгжих боломжгүй

6. Удирдлагын шийдвэр, оролцоог хэрхэн сайжруулбал илүү үр дүнтэй эсэх?

А. ГУУ-г чадавхижуулах-2 Б. Туршлагатай хүнээр ахлуулах-6 В. Дадлага сургуулийг чанартай хийх-16 Г. Онол, гүйлгээ ухаан сайн байх-26



7. Салаа бүлгийн дарга тань ажил албандаа тэнцэж шаардлага хангаж байна уу?

А. Тийм-30 Б. Үгүй-4 В. Сайн мэдэхгүй байна-0
Г. Дадлагажуулах шаардлагатай-16

Дээрх асуулгаас дараах анализ хийж үзсэн. Үүнд:

Нэгдүгээрт: Объектын гал түймэртэй тэмцэх үйл ажиллагааг сайжруулах боломж байна. Цаашлаад ард иргэдийг чадавхижуулж гал түймрийн талаар ойлголт болон түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга ухаанд сургаж дайчлах боломж байна.

Хоёрдугаарт: Алба хаагч бүр гал унтраах дадлага сургуулилыг чанаржуулж практикт ойртуулах эрмэлзэлтэй, багаж зэвсэглэмж тоног төхөөрөмжийн хэрэгцээ хүрэлцээ муу байгаа гэдэгт санал нэгдэж байна.

Гуравдугаарт: Сүүлийн 5 жилд сургуулиас төгсөж гарсан салаа бүлгийн дарга нар нь ажил албандаа шаардлага ханагхуйц ба ахлагч бүрэлдэхүүн бүр дэмжсэн байр суурьтай байна. Харин дадлага сургуулилт хийж биеэ дайчлан суралцах хэрэгтэй гэдэгт санал нийлж байна.

ОБЪЕКТЫН ГАЛ ТҮЙМЭРТ ИРГЭДИЙН ӨРТӨГДСӨН БАЙДАЛ

Монгол Улсын хэмжээнд 2019 онд нийт 4209 удаагийн ахуйн гал түймэр гарч, **11.4** тэрбум төгрөгийн хохирол учирч, **54** хүн нас барж, **68** хүн түлэгдэж гэмтэн **628** толгой мал хорогдож, **1770** гэр, орон сууц шатсан байна. Энэ нь объектын гал түймэрт иргэд олон нийтийн хайхрамж

болгоомжгүй үйлдлийн улмаас бүгд шалгаалсан байдалтай байна. Иймд дараах зүйлсийг анхаарах шаардлагатай байна.

Пийшин, зуухны янданг дээврийн гадаргуугаас 50 см-ээс багагүй өндөртэйгээр гаргах, дээвэр таазнаас яндан хүртэл 50 см-ээс багагүй зайтай байх, пийшин зуух нь хананаас 1,25 см-ээс багагүй зайтай байх бөгөөд галлагааны амны өмнө 70х50 см-ийн металл хуудас, төмөр байрлуулах,

Мөн орон сууц, гэрийн цахилгаан хангамж, цахилгаан тоног төхөөрөмжийг заавал эрх бүхий мэргэжлийн этгээдээр угсралт, засвар үйлчилгээг хийлгэх.

Бага насны хүүхдийг гэрт нь харгалзах хүнгүйгээр орхих, цоожилж үлдээхгүй байх, хөлдсөн, хөрсөн автомашиныг ил галаар гэсгээхгүй байх, галласан гэрийг эзэнгүй орхихгүй байх, цахилгаан тенз, халаагуур бусад цахилгаан хэрэгслийг ашиглахдаа цахилгаан ашиглалтын дүрэм журмыг мөрдөх, аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгаа авах, мэргэжлийн цахилгаанчаар холбуулж, холбогдох байгууллагуудаас өгч байгаа заавар, зөвлөмжийг дагаж мөрдөх зэрэг сонор сэрэмж аюулгүй байдлыг хангах нь ИРГЭН ХҮНИЙ ҮҮРЭГ гэдгийг ямагт санахтун.

ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ БОЛОМЖ, САНАЛ

- -Зам гарц, хаягжилтийг Улаанбаатар бүсийн хэмжээнд нарийвчлан явуулж хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээллэх
- Гал түймэр унтраах, аврах ангид ашиглагдаж буй багаж зэвсэглэмж, тоног төхөөрөмжийг сайжруулах, шинээр тавигдаж буй багаж зэвсэглэмжинд алба хаагч нэг бүрийг сургаж дадлагажуулах
- Шинээр томилогдож буй алба хаагч бүрт тавигдаж буй ажлын байрны шаардлагад нийцсэн эсэхэд зэргийн шалгалт авч ур чадварыг тогтоож практик, дадлага сургуулилтыг эрчимжүүлэх
- Ард иргэддээ гамшиг тус бүрээр нь шат дараатайгаар нь Онцгой байдлын албан хаагчдыг мэргэшүүлдэгтэй адил сургалтанд хамруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Ард иргэдээс ирүүлсэн санал бүрт дүн шинжилгээ хийж үзвэл хамгийн түрүүнд өөрийгөө аврах, улмаар шаардлагатай арга хэмжээ бүрийг авч бусдад туслах зэрэг үзэл баримтлал дээр тулгуурлан тэднийг томилгоожуулж хийх ажлуудыг тодорхой болгох зохион байгуулалтыг бий болгох менежментийн асуудал чухал байна.

- Иргэд дунд гал түймэр унтраах, авран хамгаалах чиглэлийн спорт уралдааныг үр дүнтэй зохион байгуулж ард иргэдийг идэвхижүүлэх
- Дүүрэг бүрт жил бүр гал унтраах үйл ажиллагаанд сайн ажилласан иргэн бүрийг шалгаруулж тодорхой хэмжээгээр ажлын байр гаргаж өгч байх, урамшуулах зэрэг өөр бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Шинэчлэгдэн батлагдсан Галын аюулгүй байдлын тухай хууль, Гал түймэр унтраах дүрмүүд нь шинэчлэн батлагдаж эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн боловч бодит амьдралд хэрэгжих явц удаашралтай байна. Тиймээс аймаг, сум, дүүргийн Онцгой байдлын газар, хэлтсүүдэд шинээр томилогдон очиж буй алба хаагч, төгсөгч сонсогчдод дээрх хууль эрхзүйн орчноос гүйцэтгэх чиг үүрэгтэй нь холбоотой зүйлсийг мэддэг болгох, түүнд зориулсан сургалтын ажлуудыг системтэйгээр явуулах шаардлагатай байна.

Мөн аж ахуйн нэгж байгууллагын ажилтнууд гал түймрийн үед ажилласан бол цалинг хэвээр олгохоос гадна хуульд заасан томилолт урамшуулалыг олгож иргэд олон нийтэд чиглэсэн сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, орон нутгийн иргэдэд хуулиар хүлээсэн эрх үүрэг болон хариуцлагын механизмыг таниулж мэдүүлэх зэрэг ажлыг чанартай зохион байгуулж ажилласанаар орон нутагт учирах хохирол тодорхой хэмжээнд буурна гэж үзэж байна.

Хууль сахиулахын Онцгой байдлын сургуулийг төгсөн гарч буй нийт сонсогчдын ихэнх хувь нь ажил албандаа бэлтгэгдсэн очсон газар хэлтэс бүртээ өөр өөрийн ажил үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа нь ахлагч бүрэлдэхүүнээс авсан судалгаагаар эерэг үр дүнтэй гарсан боловч салаа, бүлгийн захирагчийн ажил үүргийн онцлогоос хамаарч удирдлагуудад харилцан адилгүй үнэлэгдсэн, практикт туршлага дутмаг байна.

Иймд нийт төгсөгчид дор бүрнээ практикаас суралцахад анхаарал хандуудах, цахим орчин хөгжсөн цагт сургуулийн төгсөгчдийг 4, 4-н жилээр ангилж харилцан холбоог идэвхижүүлэх, нэгжүүдэд хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний ажлыг жил бүр явуулж байх нь үр дүнд хүрнэ гэж үзэж байна.

Ашигласан материал:

1. Гамшгаас хамгаалах менежментийн үндэс., УБ 2017., Ph.D
Д.Сэржмядаг
2. Орон нутгийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн
дурынхны оролцоог бий болгох арга зам., УБ 2016, магистр Б.Батбаяр
3. Галын аюулгүй байдлын тухай хууль., төрийн мэдээлэл.,
2015 он.,
4. Гал түймэр унтраах дүрэм., 2016 он.,
5. Гамшиг судлалын хүрээлэнгийн бүтээлийн эмхэтгэл., УБ
2009-2016
6. www.Nema.gov.mn